



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/362

Ховд


「 Дараа тооцохоор санхүүжилт олгох тухай 」

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт газар тариалан, тэжээлийн ургамлын тариалалтыг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйг дэмжих сангаас нийлүүлж буй үрийн үнэ, тариалалтын үйл ажиллагааны зардлын дэмжлэгт 19,150,000 төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр түр олгосугай.

2. Тус санхүүгийн дэмжлэгт олгох нийт 19,150,000 төгрөг (арван есөн сая нэг зуун тавин мянга)-ийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд төвлөрүүлсэн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх санхүүжилтээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 19,150,000 төгрөгийг "Шинэ Ховд" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон ашиглагч аж ахуйн нэгжүүдтэй тухайн үеийн зах зээлийн үнээс нэг мянган төгрөгөөс доошгүй үнээр хямд үнэтэй, стандартын дагуу пресслэсэн өвс нийлүүлэх хэлбэрээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан барагдуулах гурвалсан гэрээ хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8200 01 1060